# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*/2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/*

| № | Зорилт | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хариуцах ажилтан | Гүйцэтгэх хугацаа | Шалгуур үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлыг эрчимжүүлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.2.7, 4.1.10.1<br>• Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2;<br>• Авлигатай тэмцэх газрын 2017.12.05-ны өдрийн 01/8723 албан бичгээр ЗТХЯ-нд ирүүлсэн зөвлөмж | 1.1.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлнэ. | ДАА Н.Мөнхсүрэн | 5-11 сар | Зохион байгуулах сургалтын тоо-7 | АТГ-т 2019 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан сургалтад 52 ажилтанг хамруулсан, АТГ-тай хамтран 2019.12.09-ны өдөр “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, түүний хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ" сэдэвт сургалтыг, мөн Авлигын эсрэг хууль тогтоомжиийг таниулах сургалтыг 4 удаа, нийт 5 сургалтыг зохион байгуулсан.<br>***Хэрэгжилт 70%*** |
| | | 1.2.Авлигын эрсдэлийн үнэлгээ хийнэ. | ДАА Н.Мөнхсүрэн | 4-5 сар | Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойлогд-сон байх | ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.5-д Эрсдэлийн үнэлгээ хийх асуудлыг АТГ хариуцаж, нэгдсэн журмаар хийж байгаа, өнгөрсөн жил эрсдэлийн үнэлгээ хийсэн тул энэ жил хийх шаардлагагүй гэсэн чиглэлийг АТГ-аас өгсөн. Харин энэ оны 11 дүгээр сарын 13-нд тус байгууллагын шудрага байдлын үнэлгээг “ЭМ ЭМ СИ ЖИ” ХХК хийсэн.<br>***Үнэлэх боломжгүй*** |
| 2. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох | 2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, | ЗУГ М.Батжаргал | 1-3 сар | Цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байх | Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд санал авах хуудас нээсэн. https://www.mcaa.gov.mn/?p=629<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1;<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 заалт заалт | сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлж, мэдээллийг байршуулж байгаа байдалд хяналт тавина. | | | | |
| | | 2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулна. | ХЭЗДБГ П.Ариунболд<br>АТБТГ Г.Батбаяр<br>ЗУГ Т.Батжаргал | 1-12 сар | Цахим хуудсанд байршуулсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийн тоо-12 | ИНД-91 “Нислэгийн ерөнхий үйл ажиллагаа ба дүрэм” ИНД-115 “Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн Гэрчилгээжүүлэлт” ИНД-133 “Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа” ИНД-137 “Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа”, ИНД-171 “Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” ИНД-172 “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” ИНД-173 “Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” ИНД-174 “Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” ИНД-175 “Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”,” ИНД-119 “Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт”, ИНД-121 “Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа”, ИНД-125 “Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа” дүрмүүдийн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, санал авсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал | ХЭЗДБГ П.Ариунболд<br>АТБТГ Г.Батбаяр | 1-12 сар | Хэлэлцүүл-гийн тоо-11 | 1. ИНД-91 “Нислэгийн ерөнхий үйл ажиллагаа ба дүрэм” ИНД-115 “Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн Гэрчилгээжүүлэлт” ИНД-133 “Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа” ИНД-137 “Хөдөө аж ахуйн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | солилцох, хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг төсөлд тусгана. | | | | агаарын хөлгийн үйл ажиллагаа" дүрмүүдийн Хэлэлцүүлгийг 2019 оны 06 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.<br>2. ИНД-171 "Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" ИНД-172 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" ИНД-173 "Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" ИНД-174 "Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" ИНД-175 "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" дүрмүүдийн Хэлэлцүүлгийг 2019 оны 10 дугээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.<br>3. ИНД-91 "Нислэгийн ерөнхий үйл ажиллагаа ба дүрэм" ИНД-115 "Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн Гэрчилгээжүүлэлт" ИНД-133 "Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа" ИНД-119 "Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт", ИНД-137 "Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа", ИНД-121 "Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа", ИНД-125 "Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа" дүрмүүдийн Хэлэлцүүлгийг 2019 оны 10 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулсан.<br>4. ИНД-171 "Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт" дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 10 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. ИНД-173 “Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан.<br>6. ИНД-171 “Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 10 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан.<br>7. ИНД-171 “Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан.<br>8. ИНД-171 “Нисэхийн холбоо, навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан.<br>9. ИНД-173 “Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт” дүрмийн Хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр зохион байгуулсан.<br>Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журамын төслийг, Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн төслийг 5 дугаар сард, агаарын тээвэрлэгчийн санхүү, эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийх, нислэг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын төслийг 4 дүгээр сард тус тус хэлэлцүүлж, саналыг тусгасан.<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.2.4 | 3.1.Тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулна. | НААХЗА С.Манлай ДАА Н.Мөнхсүрэн | 2 дугаар сарын 15-ны дотор | Төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан байх | ДАА-ны 2019 онд хийх шалгалтыг хуваарийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. https://www.mcaa.gov.mn/?p=680<br>НААХЗА-ны 2019 оны төлөвлөгөөт үзлэг шалгалтын төлөвлөгөөг https://www.mcaa.gov.mn/?p=8845 байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 3.2.Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг болон хяналт шалгалтын тайланг хураангуй хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд байршуулах боломжийг бүрдүүлж, мэдээллийг байршуулж байгаа байдалд хяналт тавина. | ЗУГ Т.Батжргал | 1-12 сар | - | Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг байршуулах цэс нээсэн.<br>https://www.mcaa.gov.mn/?p=8845<br>https://www.mcaa.gov.mn/?p=680<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 3.3.Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлнэ. /цахим хуудсаар мэдээлсэн байх/ | НААХЗА С.Манлай ДАА Н.Мөнхсүрэн | Тухай бүр | Цахим хуудсанд байршуулсан байх | Хяналт шалгалтын тайланг хураангуй хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд байршуулж байна. 2019 онд ДАА-наас 18 тайлан, НААХЗА-ны хэлтсүүд үзлэг шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг улирал бүр шинэчилж цахим хуудсанд байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 3.4.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан | НААХЗА С.Манлай ДАА Н.Мөнхсүрэн | 1-12 сар | | ***Хэрэгжилт 0%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлнэ. | | | | |
| 4. | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 заалт<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.3.3, 4.1.3.4 | 4.1. ИНЕГ-ын даргын 2016 оны А/830 дугаар тушаалаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн жагсаалт”-ын дагуу тогтоосон хугацаанд мэдээллийг байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | Тогтоо-сон хуга-цаанд | Байршуулах мэдээллийн тоо-2596 | ДАА-ны зүгээс хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байна. Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээлэлд улирал бүр хяналт, шалгалт хийж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлж байна. ИНЕГ болон түүний харьяа алба салбар 2019 онд шилэн дансанд 3069 мэдээлэл байршуулахаас 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 2596 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, хэрэгжилт 94.4 хувьтай байна. 318 мэдээллийг байршуулах хуулийн хугацаа болоогүй.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 4.2.ИНЕГ-ын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлыг цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчилнэ. | СХОГ Ч.Нямсүрэн | Улирал бүр | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний мэдээллийг шинэчилсэн байх | ИНЕГ-ын 2019 оны өөрийн орлогоос санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ИНЕГ-ын 2019 оны урсгал зардлын хөрөнгөөр санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/03/Horongiin-tolovlogoo.pdf<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг шинэчлэн, улирал бүр байршуулахыг ХААТ-т анхааруулж, 10 сараас хойш мэдээллийг байршуулсан.<br>***Хэрэгжилт 70%*** |
| 5. | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах | 5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулна. | НААХЗА С.Манлай | Улирал бүр | Цахим хуудсанд байршуулсан байх | Байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрлийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.https://www.mcaa.gov.mn/?p=1752<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, 7.1.3<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.2.1.1; 4.1.2.2.2. | 5.2.Дээрх зөвшөөрөл /*тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл*/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд байршуулна. | НААХЗА С.Манлай | Улирал бүр | Цахим хуудсанд байршуулсан байх | Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгоход мөрддөг ИНБД-ийг цахим хуудсанд байршуулсан. https://www.mcaa.gov.mn/?p=1752<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулж, тогтмол шинэчилнэ. | НААХЗА С.Манлай | Улирал бүр | Цахим хуудсанд байршуулсан байх | Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг байгууллагын цахим хуудсанд байршуулж, мэдээллийг шинэчилж байна. https://www.mcaa.gov.mn/?p=1758<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 5.4.ИНЕГ-аас олгож байгаа зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг судалж, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран, цахим хэлбэрээр | НААХЗА С.Манлай<br><br>МТИСХА Б.Өнөрболд | 4-11 сар | - | ИНЕГ-аас олгож байгаа тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг судалсан. Аэродромын гэрчилгээ, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ болон агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтад |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтад оруулж, эхний ээлжинд үнэмлэх, гэрчилгээжүүлэл-тийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | | | | оруулсан. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн 1-р үе шат болон үнэмлэхжүүлэлтийн “eҮнэмлэх” системийг хөгжүүлэх ажил дуусч, 2020 оны 2 дугаар сарын 01-нээс нэвтрүүлэхээр төлөвлөж байна. ***Хэрэгжилт 70%*** |
| | | 5.5.Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгуулагад шилжүүлэх боломжийг судална. | НААХЗА С.Манлай ХЭЗДБГ П.Ариунболд | 4-10 сар | - | Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан” Аюулгүй ажиллагааны хяналт”-ын doc 9734-ын 2.3.1-д “ажилтнуудын үнэмлэх, гэрчилгээжүүлэлт, агаарын хөлөг, агаарын тээвэрлэгч, аэродромын гэрчилгээжүүлэлтийн ажлыг зохион байгуулах нь Чикагогийн конвенц, түүний хавсралтуудад заасны дагуу тухайн Улсын үүрэг байна” гэж заасан. Мөн doc 9734- ын 3.2.4-т Нисэхийн гол/үндсэн хууль тогтоомжид “иргэний агаарын тээврийн үйл ажиллагааг идэвхтэй хянах, зохицуулах ялангуяа агаарын хөлгийн ашиглалт, түүнийг бүртгэх, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллага буюу ИНЕГ-ыг хуульчилсан зохицуулалтыг тусгасан байх ёстой” гэж заасан. Олгож буй тусгай зөвшөөрөл нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2-т “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон байдлыг хангуулахад чиглүүлнэ” гэж заасан. Иймд иргэний нисэхийн салбарт олгож буй тусгай зөвшөөрөл, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх нь Монгол Улсын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгдэж орсон олон улсын гэрээ конвенци болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагатай зөрчилдөх тул боломжгүй гэж НААХЗА үзэж байна.<br>***Үнэлэх боломжгүй.*** |
| 6. | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.1.1;<br>• Авлигатай тэмцэх газрын 2017.12.05-ны өдрийн 01/8723 албан бичгээр ЗТХЯ-нд ирүүлсэн зөвлөмж | 6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулна. | ЗУГ Т.Батжаргал | Тухай бүр | Байршуулсан сул орон тооны зарын тоо-9 | 2019 онд 9 ажлын байранд сонгон шалгаруулалт зарласан. Үүнд:<br>-Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга;<br>-НБУГ-ын баримт бичиг боловсруулалтын мэргэжилтэн;<br>-НБУГ-ын судалгаа үнэлгээний инженер;<br>-НБУГ-ын Хүний нөөцийн мэргэжилтэн /түр хугацаагаар/;<br>-“Чойбалсан” нисэх буудлын нягтлан бодогч;<br>-Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албанд Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зохицуулагч инженер.<br>- Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Чанар хяналтын инженер<br>- Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Нийтийн эзэмшлийн бүсийн тохижилт, ногоон байгууламж хариуцсан технологич<br>- Баян-Өлгий аймгийн нисэх буудлын дарга<br>***Хэрэгжилт 30%*** |
| | | 6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана. | ЗУГ Т.Батжаргал | 1-12 сар | - | Дорнод аймгийн нисэх буудлын нягтлан бодогчийн ажлын байрны зарыг Чойбалсан хотын 2 телевизийн сувгаар нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт зохион байгуулсан.<br>***Хэрэгжилт 70%*** |
| | | 6.3.Байгууллагын хүний нөөцийн жагсаалт, ажлаас | ЗУГ Т.Батжаргал | Улирал бүр | - | Байгууллагын ажилтнуудын албан тушаал болон дотуур утасны жагсаалтыг цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал хуудсанд байршуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгоно. | | | | https://www.mcaa.gov.mn/?p=673<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 6.4.Албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх, түүний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахгүй, ажилтныг шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллана. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-12 сар | - | 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 209 ажилтанг шилжүүлэн ажиллуулсан бөгөөд үүнээс 27 ажилтныг албан тушаал дэвшүүлэн томилсон. Албан тушаал дэвшүүлэн ажиллуулсан 27 ажилтан нь салбартаа 2-оос дээш жил ажилласан, ажлын туршлагатай ажилтнууд байгаа болно. Мөн үеийн байдлаар 59 иргэнийг шинээр ажилд авсан. Албан тушаалд иргэнийг томилохдоо чадахуйн болон шатлан дэвшүүлэх зарчмыг баримтлаж байна.<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 6.5. Иргэний нисэхийн чиглэлийн хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааг жил бүр хийж, хэрэгцээ шаардлагыг үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэнэ. | ЗУГ<br>Т.Батжаргал<br><br>АТБТГ<br>Г.Батбаяр | 1-12 сар | Шаардлагатай хүний нөөцийн тоо | Ирэх 3 жилд шаардлагатай нисэхийн нарийн мэргэжлийн жагсаалтыг гаргасан. Түүний дагуу 2019 онд 11 оюутанг суралцуулахаар шийдвэрлэсэн.<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 6.6.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг боловсруулж, батлуулан, цахим | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-6 сар | Батлагдсан баримт бичгийн тоо | Хүний нөөцийн стратегийн төслийг боловсруулж байна.<br><br>***Хэрэгжилт 30%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хуудсанд барйшуулна. | | | | |
| 7. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;<br>• Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5<br>• Авлигатай тэмцэх газрын 2017.12.05-ны өдрийн 01/8723 албан бичгээр ЗТХЯ-нд ирүүлсэн зөвлөмж | 7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим хуудсанд байршуулна. */1 дүгээр сарын 10-ны дотор/* | СХОГ Ч.Нямсүрэн | 1 дүгээр сард | - | ИНЕГ-ын 2019 оны өөрийн орлогоос санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ИНЕГ-ын 2019 оны урмгал зардлын хөрөнгөөр санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. http://www.mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/03/Horongiin-tolovlogoo.pdf<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам */тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/*, тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | 1-12 сар | - | Тендерийн зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. https://www.tender.gov.mn/mn/invitation?year=2019&selGovernorId=125&selClientId=1453535505354&get=1<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 7.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | 1-12 сар | - | www.tender.gov.mn- д мэдээллийг байршуулж байна.<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 7.4.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | 1-12 сар | - | Шилэн дансанд мэдээллийг байршуулж байна. ***Хэрэгжилт 100%*** |
| | | 7.5.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | 1-12 сар | - | Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулсан. 2019 онд худалдан авах ажиллагаанд аудит хийгдээгүй болно. ***Хэрэгжилт 100%*** |
| | | 7.6.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна. | СХОГ Ч.Нямсүрэн | Тухай бүр | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулж байна. ***Хэрэгжилт 100%*** |
| | | 7.7Албан тушаалтан тендерийн үнэлгээний хороонд ажиллахдаа ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл | СХОГ Ч.Нямсүрэн | Шийдвэр гарснаас 7 хоногийн дотор | Мэдэгдлийг 100%-д системд оруулсан байна. | 2019 онд тендерийн үнэлгээний хороонд ажилласан 132 албан хаагчаас мэдэгдлийг гаргуулж, шилэн дансанд байршуулсан. ***Хэрэгжилт 30%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх, мэдээллийг Шилэн данс цахим хуудсанд байршуулна. | | | | |
| | | 7.8.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, зар зэргийг цахим хуудсанд байршуулах цэс үүсгэж, мэдээлэл байршуулж байгаа байдалд хяналт тавина. | ЗУГ Т.Батжаргал | 1-12 сар | | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын цахим хуудасны Ил тод байдал хэсгийн Худалдан авах ажиллагааны ил тод байдал хуудсанд цэс нээсэн. https://www.mcaa.gov.mn/?p=678. ***Хэрэгжилт 100%*** |
| 8. | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга | 8.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлнэ | ЗУГ Т.Батжаргал | 1-12 сар | | ИНЕГ-ын 91 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн, албан тушаалд тавигдах тусгай шаардлагуудыг шинэчилсэн. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагад үндэслэн томилгоо хийж байна.<br><br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний төлөвлөгөө 4.1.1.2 | 8.2.Албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулна. | ЗУГ<br>Т.Батжаргал | 4 сар | Батлуулсан АТТ-ын тоо-100 | Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан ИНЕГ /агентлаг/-ын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг тус журам, зохих маягтад нийцүүлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2019.04.22-ны өдрийн А/323 тушаалаар байгуулсан. ИНЕГ-ын 91 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн, 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдөр ИНЕГ-ын даргаар батлуулсан.<br>***Хэрэгжилт 70%*** |
| | | 8.3.Эрхэлж байгаа ажлын онцлогтой нь уялдуулан түүнд хориглох зүйлийг тогтоож, АТТ-д тусгана. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-6 сар | | Албан тушаалын тодорхойлолтод Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай холбоотой зүйл заалтаас оруулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| 9. | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох зохицуулалтыг бий болгох<br>***Эрх зүйн үндэслэл:*** | 9.1.Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг ЗГ-ын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн шинэчлэн, баталж, хэрэгжүүлнэ. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-12 сар | Батлагдсан баримт бичгийн тоо<br><br>Танилцуулах сургалтад хамрагдсан ажилтны тоо | ЗГ-ын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан журманд нийцүүлэн “Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж байна.<br>***Хэрэгжилт 30%*** |
| | • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.1.3; | 9.2.Албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ. | НБУГ<br>Д.Эрдэнэбаатар<br>“Чингис хаан” ОУНБ<br>Д.Мөнхбаатар | 1-12 сар | | ***Хэрэгжилт 0%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10. | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгуул-лага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан орол-цуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.7.3.1; | 10.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-12 сар | | ***Хэрэгжилт 0%*** |
| 11. | Давхар ажил эрхлэх боломж-той эсэхийг шийдвэрлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг со-нирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл | 11.1. Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа хийнэ. | ДАА<br>Н.Мөнхсүрэн | 4-5 сар | | Судалгаа авсан.<br>***Хэрэгжилт 70%*** |
| | | 11.2. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулна. | ДАА<br>Н.Мөнхсүрэн | 5 сар | | ХАСХОМ гаргахтай холбогдуулан 2019 онд 1 дүгээр сард зохион байгуулсан сургалтын үеэр жагсаалтыг танилцуулж, жагсаалтыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12. | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 | 12.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж, мэдээлэл байршуулж байгаа байдалд хяналт тавина. /цахим хуудсаар/ | ЗУГ Т.Батжаргал | I улирал | | Цэсийг нээсэн. http://mcaa.gov.mn/?p=629#<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 12.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсандаа байршуулна. | ЗУГ Т.Батжаргал | 1-12 сар | Байршуулсан тушаалын тоо | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг цахим хуудсанд байршуулж, шинэчилж байна. 2019 онд ИНЕГ-ын даргын гаргасан нийтэд хамаатай 407 тушаал шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. http://mcaa.gov.mn/?p=629#<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 12.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулна. | ХЭЗДБГ П.Ариунболд | 1-12 сар | | Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгүүдийг http://mcaa.gov.mn/?p=673 цахим хуудсанд байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 12.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулна. | СХОГ Ч.Нямсүрэн<br>НБУГ Д.Эрдэнэбаатар<br>"Чингис хаан" ОУНБ Д.Мөнхбаатар<br>ГТҮА С.Чинзориг | 4 сар | | "Чингис хаан" ОУНБ-ын үнэ тарифыг тус нисэх буудлын цахим хуудсанд байршуулсан. http://airport.gov.mn/tarif.html<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13. | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг со-нирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;<br>• Иргэдээс төрийн байгуул-лага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг | 13.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилна. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-12 сар | | Байгуулагын зүгээс хийж хэрэгжүүлж буй ажлуудыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авлаа. Үүнд:<br>-Улаанбаатар хотын ОУШНБ-ын ажлын явц, ашиглалтын талаар, Бойнг MAX 8 онгоц болон манай улсад нисэхийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажилладаг талаар ИНЕГ-ын дарга, Дэд дарга нараар телевизэд дэлгэрэнгүй ярилцлага, БНСУ, БНТУ-тай хийсэн агаарын харилцаанд нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай мэдээлэл, ярилцлага, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын концессийн гэрээг үзэглэх, хэсэгчилсэн нээлтийн сурвалжлага, мэдээлэл, ярилцлага, Нисэхийн эрэн хайх, авран туслах дотоодын байгууллагуудыг хамруулсан анхны Дотоодын SAREX зохион байгуулсан зэрэг сэвдүүдээр давхардсан тоогоор 18 сайт, өдөр тутмын 5 сонин, 13 телевизээр 2019 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар 89 мэдээ, мэдээлэл, ярилцлагыг тухай бүрт нь мэдээлж, олон нийтэд хүргэлээ.<br>-2019 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар ИНЕГ-ын цахим хуудсанд 161 мэдээ, мэдээллийг байршуулж, олон нийтэд хүргэлээ.<br>- Долоо хоног бүрийн эхэнд болдог Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнөөс мэдээ бэлтгэн байгууллагын вэб сайтад оруулж байна.<br>-Засгийн газрын албан ёсны **WWW.ZASAG.MN** вэб хуудсанд мэдээ оруулах админ эрх гуравдугаар сард авч нийт 26 мэдээ, мэдээлэл нийтлэн ИНЕГ-ын мэдээллийг Засгийн газрын цахим хуудсанд тогтмол оруулах ажлыг санаачлан хэрэгжүүлж ажиллаж байна.<br>- Захиалгын гэрээтэй хамтарч ажилладаг өдөр тутмын Өдрийн сонин, Үндэсний шуудан, Монголын мэдээ, Монголын үнэн, Зууны мэдээ сонинуудад алба салбаруудад хийгдсэн ажлын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаарх тогтмол мэдээлэл гаргах хуваарийг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж, алба, салбаруудаас ирүүлсэн 20 гаруй мэдээллийг сонинуудад нийтлүүллээ.<br>- Долоо хоног бүрийн даваа гаригт Нислэгийн долоо хоногийн мэдээллийг, мөн сар бүрийн эхний 15 хоногт өмнөх сарын нислэгийн нэгдсэн мэдээллийг инфо графикаар гаргаж олон нийтэд мэдээллэх ажлыг тогтмолжуулж байгууллагын www.mcaa.mn вэб хуудас болон Пэйж хуудас, Засгийн газрын **WW.ZASAG.MN** сайтад тавьж тогтмол мэдээлж байна.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 13.2.Өргөдөл, гомдлын асуудал хариуцсан албан хаагчийн овог нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудсанд байршуулна. | ЗУГ Т.Батжаргал | 4 сар | | Тус байгууллагын цахим хуудсанд өргөдөл, гомдол хүлээн авах эрх бүхий эрх бүхий ажилтны мэдээлэл, утасны дугаар болон өргөдөл, гомдол шийдвэрлэх журмыг https://www.mcaa.gov.mn/?p=4825 хэсэгт байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 13.3.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлнэ. | ЗУГ Т.Батжаргал | Улирал бүр | | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг байгууллагын цахим хуудсанд улирал бүр байршуулж байна.<br>https://www.mcaa.gov.mn/?p=4775&lang=en<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6<br>• Авлигатай тэмцэх газрын 2017.12.05-ны өдрийн 01/8723 албан бичгээр ЗТХЯ-нд ирүүлсэн зөвлөмж | 14.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЗУГ<br>Т.Батжаргал | 1-12 сар | Хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх | Худалдан авах ажиллагаанд авлигын эрсдлийг бууруулах, авлига авах боломжийг таслан зогсоох зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн төлөөлөл, хувийн хэвшлийн төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөлийг оруулж байна. Үүнээс гадна тендерийн үнэлгээний хороонд ажиллахдаа ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухай бүр бичгээр тайлбар хийж байна. Санхүү болон худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа ажилтнуудыг сэлгэн ажиллуулахдаа Хөдөлмөрийн дотоод журмын 3.6.6 дахь заалтыг мөрдөж ажиллаж байна. 2019 онд 209 ажилтныг шилжүүлэн ажиллуулснаас 24 хүнийг дэвшүүлэн томилсон. ИНЕГ-аас олгож байгаа тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг судалсан. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн 1-р үе шат болон үнэмлэхжүүлэлтийн “еҮнэмлэх” системийг хөгжүүлэх ажил дууся, 2020 оны 2 дугаар сарын 01-нээс нэвтрүүлэхээр төлөвлөж байна. ***Хэрэгжилт 100%*** |
| | | 14.2.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсооно. | ЗУГ<br>Т.Батжаргал<br>ДАА<br>Н.Мөнхсүрэн | 1-12 сар | | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсны дараа албан тушаалд томилж байна.Ийм төрлийн зөрчил гараагүй. 2019 онд 31 мэдүүлгийг АТГ-т хүргүүлж хянуулж, 26 нэр дэвшсэн этгээдийг томилсон.<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 14.3.Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргаж, хэвшүүлэх, хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, худал мэдүүлсэн албан хаагчдад хариуцлага тооцно. | ДАА<br>Н.Мөнхсүрэн | 1-12 сар | | Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргуулж хэвшсэн. ХАСХОМ гаргахтай холбогдуулан 2019 онд 1 дүгээр сард зохион байгуулсан сургалтын үеэр албан тушаалд томилогдсоноос хойш хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргахыг ажилтнуудад танилцуулсан бөгөөд томилогдсон албан тушаалтанд тухай бүр мэдэгдэж байна. Мэдүүлгээ хугацаа хоцроосон албан тушаалтан байхгүй байна. 2019 онд ХАСХОМ-ээ худал мэдүүлсэн 1 ажилтанг АТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу ажлаас нь чөлөөлсөн.<br>***Хэрэгжилт 100%*** |
| | | 14.3.Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд | ДАА<br>Н.Мөнхсүрэн<br><br>СХОГ<br>Ч.Нямсүрэн<br><br>ЗУГ<br>Т.Батжаргал<br><br>“Чингис хаан” ОУНБ<br>Д.Мөнхбаатар | 1-12 сар | | НАНБХАЗАСЗУСХ-ийн 8.1-д заасны дагуу албан тушаалтан тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахад заавал ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулж хэвшсэн. 2019 онд үнэлгээний хороонд ажилласан 983 албан хаагчаас мэдэгдлийг гаргуулж, Авлигатай тэмцэх газраас баталсан бүртгэлийн маягтын дагуу бүртгэж, АТГ-ын “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм” дахь “ЭБАТ” цэсний мэдэгдэл, тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл хэсэгт оруулсан. Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийхэд ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөлд АСМ-ийг гаргуулж байна. 2019 онд тус байгууллагын удирдах 11 ажилтан захиргааны шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн мэдэгдлийг гаргасан.<br>***Хэрэгжилт 70%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүргүүлэх ажлыг хэвшүүлнэ. | | | | |
| | | 14.4.ИНЕГ-ын удирдах албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож байгаа үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авна. | ЗУГ<br>Т.Батжаргал | | | Захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулахдаа удирдлагууд санал авах хуудсанд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар тэмдэглэгээ оруулж хэвшсэн. Мөн ИНЕГ-ын ХАСХОМ гаргадаг ажилтнуудын хамаарал бүхий этгээдийн болон компани, нөхөрлөл хоршоонд оруулсан хөрөнгө оруулалтын судалгааг гаргасан. Иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн тохиолдлыг илрүүлж, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл авах зорилгоор буланг байгууллагын цахим хуудаснаа нээн ажиллуулж байна. Одоогоор авлигатай холбоотой ямар нэгэн мэдээлэл ирээгүй байна.<br>***Үнэлэх боломжгүй*** |
| 15. | Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх<br>***Үндэслэл:***<br>• Авлигатай тэмцэх газрын 2017.12.05-ны өдрийн 01/8723 албан бичгээр ЗТХЯ-нд ирүүлсэн зөвлөмж | 15.1.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгоно. | ДАА<br>Н.Мөнхсүрэн | 1-12 сар | | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд http://mcaa.gov.mn/?p=2995 байршуулж нийтэд ил тод болгосон. 2019 онд хянуулсан 31 ХАСУМ-ийг байршуулсан.<br>***Хэрэгжилт 100%*** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16. | Байгууллагын үйл ажиллагааг ил тод болгоно.<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт | 16.1.Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг байгууллагын цахим хуудсанд байршуулна. | ЗУГ<br>Б.Батжаргал | I улирал | | ИНЕГ-ын жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг байгуулагын цахим хуудасны ил тод байдал хэсгийн Үйл ажиллагааны ил тод байдал хуудсанд байршуулсан.<br>https://www.mcaa.gov.mn/?p=670<br><br>***Хэрэгжилт 70%*** |
| 17. | Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх<br>***Үндэслэл:***<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.2.4.3; | 17.1.Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбуулах болон төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох боломжийг судалж, дүгнэлт гаргана. | МТИСХА<br>Б.Өнөрболд | 4-12 сар | | Төрийн нэгдсэн мэдээллийн "ХУР" системд ИНЕГ-ын зарим мэдээллүүдийг оруулсан.<br><br>***Хэрэгжилт 100%*** |
| 18. | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;<br><br>***Үндэслэл:***<br>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг | 18.1ШӨХТГ-тай холбогдож, тус байгууллагаас боловсруулж байгаа хөтөлбөрт агаарын тээврийн өрсөлдөөнт орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох заалтыг | АТБТГ<br>Г.Батбаяр | 4-6 сар | | Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар боловсруулсан “Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төсөлд Зам, тээврийн хөгжлийн яам саналаа өгсөн бөгөөд хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэр Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тусгагдаагүй тул хөтөлбөрийн төслийг дэмжих боломжгүй байгааг Сангийн яам мэдэгдсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4.1.6.4.4 | тусгах арга хэмжээ авна. | | | | ***Үнэлэх боломжгүй.*** |
| | | 18.2.Орон нутгийн хуваарьт нислэгийн чиглэлийн хуваарилалт, тариф тогтоох, мөрдөх, үйл ажиллагааны зохион байгуулалтыг чөлөөт өрсөлдөөний зарчмаар хэрэгжүүлэх журмыг боловсруулж, батлуулна. | АТБТГ Г.Батбаяр | 5-12 сар | | ЗТХС-ын 2019 оны 187 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам”-ын 4.1.4-д заасны дагуу нисэх буудлын үйлчилгээний хураамжийг зохицуулж байна. ***Хэрэгжилт 100%*** |
| **Хэрэгжилтийн дундаж хувь- 85 %** | | | | | | |